



АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/208

Улаанбаатар хот

“Ажилтны сургалтын ба мэдлэг чадвар
бий болгох хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар
хуулийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг,
5 дугаар зүйл, Төрийн өмчийн хорооны 2015 оны 3-р сарын 26-ны өдрийн 174 дүгээр
шаргууламгаар батлагдсан “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын
хуулийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалт, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар
хуулийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын “Ажилтны
сургалтын ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Ажилтны сургалтын ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”-ийн дагуу
хэрэгжих сургалтын зардлыг жил бүрийн Зорилтот түвшинд тусган батлуулахыг Санхүү,
Мөнгө оруулалтын газар /Ц.Бат-Өлзий/-т зөвшөөрсүгэй.

3. “Ажилтны сургалтын ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”-ийг нийт
станд танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар
Мөнхбаяр/-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Н.ПУНЦАГ

“Автотээврийн үндэсний төв” төрийн
өмчит үйлдвэрийн газрын захирлын
2015 оны 14 дугаар сарын 14-ны өдрийн
14 дугаар тушаалын хавсралт



“АЖИЛТНЫ СУРГАЛТЫН БА МЭДЛЭГ ЧАДВАР БИЙ БОЛГОХ ХӨТӨЛБӨР”

Нэг. Оршил

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар /цаашид “Үйлдвэрийн газар” гэх/ нь хувь хүний мэдлэг чадвар, туршлагыг эрхэмлэн нээлттэй бүтээлч сэтгэлгээнд тулгуурлан, багаар ажиллах тогтолцоог хэрэгжүүлснээр ажилтны эрх зүйлс, хариуцлагыг өндөржүүлэн, мэргэшсэн, тогтвортой, чадварлаг албыг бүрдүүлэх нь тус Үйлдвэрийн газрын тулгамдсан асуудал, хэтийн хөгжлийн үндэс болж байна.

Үйлдвэрийн газар нь тасралтгүй суралцагч байгууллагын хандлагад суурилж хувь хүний чадварыг хөгжүүлж, ажилтныг чадварлаг болгон төлөвшүүлснээр бүтээмжийг бий болгоно. Улмаар ажилтан болон Үйлдвэрийн газар хооронд харилцан үнэнч байх чадвар дээшилж, байгууллагын соёл, үнэт зүйлс бэхжинэ.

Иймд ажилтныг ажил хэрэгтээ бие сэтгэлээ бүрэн зориулах, тэдний ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хөгжүүлэх талаар анхаарч ажиллах шаардлага чухлаар тавигдаж байгаа бөгөөд хүний нөөцийг хэрхэн бэлтгэж, мэргэшүүлснээс Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдах үндэслэл болж байна.

Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, хүний нөөцийг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг дээшлүүлэх асуудлыг Үйлдвэрийн газрын хэтийн төлөвлөгөө болон салбарын хэтийн хөгжилтэй уялдуулан төлөвлөж хэрэгжүүлнэ.

Түүнчлэн Үйлдвэрийн газрын үйл ажиллагаа нь авто тээвэрлэлтийн аюулгүй байдалтай холбоотой асуудал төдийгүй улсын хэмжээнд эдийн засаг нийгэм, үндэсний аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрүүл мэнд, тэдний амьдралтай шууд холбоотой учир Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хамрах хүрээ, чиг үүрэг, ажлын горим, ажиллах хүчин чадал, мэдээллийн систем, технологи, техник, тоног төхөөрөмж, програм хангамж түүнийг ашиглахад тавигдах шаардлагыг харгалзан мэргэжлийн ажилтнуудын мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, мэргэшүүлэн бэлтгэх нь чухал асуудал болж байна.

Мөн өндөр хөгжилтэй гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын үйл ажиллагааг судлах, танилцах, туршлага судлах зайлшгүй шаардлага гарч байгаа болно.

Хоёр. Хөтөлбөрийн үндэслэл

2.1.Хөтөлбөрийг Монгол Улсын "Авто тээврийн тухай" хууль, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хэтийн төлөв, "Хөдөлмөрийн дотоод журам" зэрэг баримт бичгийг үндэслэн боловсруулав.

2.2.Үйлдвэрийн газрын "Ажилтны сургалтын ба мэдлэг, чадвар бий болгох хөтөлбөр" /цаашид "хөтөлбөр" гэх/-ийн зорилго нь Үйлдвэрийн газрын ажилтны шаардлагатай сургалт, мэдлэг чадварыг бий болгох, тэднийг хөгжүүлэн мэргэшсэн чадварлаг цомхон багийг бүрдүүлэхэд оршино.

2.3.Автотээврийн талаар хэрэгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд Үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчны өөрчлөлт шинэчлэлт нь ажилтнаас өндөр мэдлэг, чадвар, өргөн хүрээтэй шинэ мэдлэг, хандлага, хариуцлагыг шаардаж байна. Иймд тэдний суралцах явдлыг хөхүүлэн дэмжих болон үйл ажиллагааны явцад ажилтнууд мэдлэг, ур чадвар, мэдээлэл туршлагаа харилцан хуваалцаж, шаардлагатай үед зохион байгуулалттай сургалтад хамруулснаар Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чадавх дээшилнэ.

2.4.Үйлдвэрийн газар нь ажилтны мэдлэг чадвар бий болгохтой холбогдсон шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулах, дэмжихэд энэхүү хөтөлбөрийг баримтална.

Гурав. Хугацаа

3.1. Хөтөлбөрийг 2015-2019 оныг дуустал 4 жилийн хугацаанд мөрдөнө.

Дөрөв. Хөтөлбөрийн бодлого

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах бодлогыг баримталж ажиллана.

4.1.1. Зах зээлийн эдийн засгийн өөрчлөлтийн мэдрэмжтэй ажиллах

4.1.2. Нийгэм, соёл, байгаль орчны өөрчлөлтийн мэдрэмжтэй ажиллах

4.1.3. Ил тод байдлыг эрхэмлэх

4.1.4. Адил тэгш бололцоогоор хангах

4.1.5. Үүрэг, хариуцлагын тогтолцоог хүлээх

4.1.6. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны албаны чадавхыг чанаржуулах

4.1.7. Үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх

4.1.8. Иргэдээс Засгийн газарт итгэх итгэл буюу эдийн засаг нийгэм, эдийн засгийн аюулгүй байдал, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэдний амьжиргааны түвшинг дээшлүүлэх

Тав. Суралцагч байгууллага болох

5.1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө нь ажилтан бүрийн мэдлэг чадвар хэр байгаа болон түүнийг хэр хэмжээнд ашиглаж байгаатай шууд хамааралтай болно. Үйлдвэрийн газар нь өөрийн үйл ажиллагаагаа сайжруулахын тулд суралцгагч суралцаж, суралцах шинэ арга барилыг идэвхтэй хэрэглэдэг "Суралцагч байгууллага" болно.

5.2. Тодорхой орчинд аливаа гол үүргийг гүйцэтгэх хувь хүний чадварыг мэдлэг чадвар гэж ойлгоно. Үүнд: Хүний онолын мэдлэг, ур чадвар, туршлага, хувийн шинж чанар, үнэт зүйлс багтана.

5.3. Ажилтан нь мэдлэг чадвараа байнга дээшлүүлж ажиллана. Мэдлэг чадварыг мэргэжлийн, нийгмийн, үйл ажиллагааны гэсэн төрөлд хувааж үзнэ. Эдгээр нь адил ач холбогдолтой байна.

- **Мэргэжлийн мэдлэг чадвар.** Ажилтны эзэмшсэн тодорхой салбарын мэргэжлээр тодорхойлогдоно. Хуульч, эдийн засагч, инженер, менежер гэх мэт
- **Нийгмийн мэдлэг чадвар.** Түнштэйгээ хамтран ажиллах, Үйлдвэрийн газрын үйлчлүүлэгчтэй харилцах зэрэгт хамаарах мэдлэг чадвар.
- **Үйл ажиллагаа /бизнес/-ны мэдлэг чадвар.** Үйлдвэрийн газрын эрхэлж байгаа тодорхой үйл ажиллагаа /бизнес/-тай холбоотой

Зургаа. Манлайлал ба оролцооны түвшинг хангах

6.1. Үйлдвэрийн газрын удирдлага нь суралцах бүх хэлбэр /ажилтан ажлын байран дээр байгууллагын болон өөрийн хөрөнгөөр суралцах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх урт, богино хугацааны сургалтад хамрагдах/-ийг дэмжүүлэн дэмжинэ.

6.2. Ажилтанд нь сургалтаас урам зориг авч идэвхжин, Үйлдвэрийн газрын ажилд мэргэжил, ажлын дадлага, туршлага, ухамсар, ажлын идэвхтэй оролцоогоор хувь нэмэр оруулна.

6.3. Үйлдвэрийн газар нь ажлын байранд тавигдах шаардлага хангасан мэдлэг чадвар, туршлага бүхий иргэдийг ажилд авах, ажилтнуудын шаардагдах мэдлэг, чадварыг дээшлүүлэх үүрэг хүлээнэ.

6.4. Үйлдвэрийн газрын зүгээс ажлын байран дээр суралцах шаардлагатай орчин, нөхцөлийг бий болгох талаар санаачилгатай ажиллана.

6.5. Олон улсын төвшинд хүний нөөцийг бэлтгэх механизмтай болгоно.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам, хэлбэр

7.1. Үйлдвэрийн газар нь ажилтнаа ажлаас хөндийрүүлэхгүйгээр сургалтанд оролцоулах тогтолцоог боловсронгуй болгож хэтийн болон тухайн онд мэдлэг чадварыг

болгох эрэлт хэрэгцээг үнэлэн урьдчилан тодорхойлж, түүнийг жил бүр төлөвлөн байн оны сургалт хөгжлийн хөтөлбөр/ хэрэгжүүлнэ.

7.2. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн үр дүнг тооцож, түүнийг сайжруулах чиглэлээр олгох холбоотой хэрэгжүүлнэ.

7.3. Ажилтны сургалт нь бүх төвшин /бакалавр, магистр, Ph.D, Sc.D, мэргэшүүлэх, давтан сургах/-ийг хамарна.

7.4. Ажилтныг сургалтанд хамрах бололцооноос хамааруулан суралцагчийг ажлаас нь бүрэн болон хагас чөлөөлж эсхүл ажиллахын зэрэгцээ суралцах амжилтаараар сургалтыг зохион байгуулна.

7.5. Ажилтны ажлын байранд Засгийн газар, авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгдсэн зорилтот сургалтуудаар дотооддоо болон гадаад хөгжилтэй гадаад орны ижил төстэй байгууллагуудад дадлага хийлгэх, урт, богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах замаар давтан бэлтгэнэ.

7.6. Сургалтын хэрэгцээгээ ажилтан өөрөө, Үйлдвэрийн газрын сургалтын төвөөс хэрэгцээг удирдлага, ажилтан хамтран тодорхойлно.

7.7. Олон улсын байгууллага болон гадаад орнуудад ажилтанг томилон ажиллуулах, сургаж хөгжүүлэх асуудлаар холбогдох дээд шатны байгууллагатай хамтран ажиллах бодлогыг барина.

7.8. Сургалтыг Үйлдвэрийн газрын боломжит бүх нөөцийг ашиглан өдөр тутмын ажиллагааны явцад ажилтны мэдлэг, ур чадвар, туршлагыг оролцогчийн хувьд нь өргөтгөж сургагчаар ажиллуулна.

7.9. Ажилтан бүрийн мэдлэг, туршлагын давуу тал, алдаа онооноос суралцана.

7.10. Сургалтыг оролцооны бүх арга /багаар ажиллах, өдөр тутмын уулзалт, төслийн ажил, шийдвэрлэх асуудал дээр тулгуурлан суралцах, шавилан суралцах, ажил сэлгүүлэн ажиллуулах, зайны сургалт/-ыг ашиглана.

7.11. Төрийн болон төрийн бус бусад байгууллага хооронд туршлага судалж, мэдээлэл солилцоно.

Найм. Хөтөлбөрийн хөрөнгийн эх үүсвэр

8.1. Үйлдвэрийн газар нь хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн Төрийн өмчийн хороотой Үйлдвэрийн газрын захирлын байгуулах контракт гэрээ, Үйлдвэрийн газрын үйл ажиллаганы төлөвлөгөө, зорилтот төвшинд тусган хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр нь дараах хөтөлбөртэй байна. Үүнд:

8.2.1. Засгийн газрын тэтгэлэг

8.2.2. Авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зардал

8.2.3. Зорилтот түвшин/жилийн зарлагын төсөвт төсөвлөж тусгах, зарлагын хэмнэлт г.м/

8.2.4. Олон улсын төсөл, хөтөлбөр

8.2.5. Ажилтны хувийн зардал

Ес. Хөтөлбөрийн үр дүн

9.1. Үйлдвэрийн газар нь ажлын байран дахь сургалтыг хэвшүүлж /хүний нөөцийн автан болон мэргэжлийн сургалтанд өндөр хөгжилтэй орны жишиг тогтолцоог хэвшүүлэх/, суралцагч байгууллага болсон байна.

9.2. Үйлдвэрийн газар нь ажлын байрны шаардлага хангасан өндөр боловсрол, мэдлэг чадвартай, ажлын дадлага туршлага бүхий, мэргэшсэн ажилтнаар хүний нөөцөө хэвшүүлсэн байна.

9.3. Мэргэжлийн болон эрдмийн зэрэг, цолтой ажилтнуудын тоо, ажилтны мэдлэг, мэргэшлийн түвшин ахисан байна.

9.4. Ажилтны үр чадвар, туршлага /Хууль тогтоомж, Засгийн газрын буюу тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс гаргасан шийдвэрийн биелэлт, Төрийн өмчийн хороотой Үйлдвэрийн газрын захирлын байгуулах контракт үндэсний биелэлт, Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, Үйлдвэрийн газрын дотоод дүрэм журмуудын хэрэгжилт, ажилтны ажлын байрны дорхойлолтод заагдсан чиг үүрэг, үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар/-ын түвшин хэвшилсэн байна.

9.5. Ёс зүйтэй, Үйлдвэрийн газрын соёл, үнэт зүйлийг эрхэмлэгч ажилтантай хамт, сахилгын зөрчил гаргасан ажилтны тоо буурсан байна.

Арав. Хөтөлбөрийн үр нөлөө

10.1. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны зорилт, чиг үүрэг тасралтгүй, чанартай, залгамж холбоон дээр явагдах нөхцөл төлөвшинэ.

10.2. Улсын хэмжээнд эдийн засаг нийгэм, үндэсний аюулгүй байдлын үүрэг гүйцэтгэлтийн түвшин сайжирна.

10.3. Тээвэрлэлтийн аюулгүй байдал хангагдаж, осол зөрчлийн хэмжээ буурч, эдийн амь нас, эрүүл мэндийн баталгаа хангагдах нөхцөл бүрднэ.

10.4. Төрийн зүгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээ чанаржиж, авто тээвэрлэлтийн үйлчилгээний чанар сайжирч, хэрэглэгчийн эрэлт өсөн нэмэгдэх хэмжээгээр бүтээм дэх ажилгүйдэл, ядуурлын түвшин буурна.

10.5. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чанар, бүтээмжийн түвшин /үйл ажиллагааны цар, хүрээ/ сайжирна.

10.6. Ажилтан нь ажлын байрны чиг үүргээ чанарын өндөр төвшинд гүйцэтгэх, шаардлага гадны сөрөг нөлөөллөөс ангид байнгын идэвхтэй, тогтвортой үйл ажиллагаа үзүүлэх орчин нөхцөл, нийгмийн баталгаа хангагдана.

Арван нэг. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх, хянах

11.1. Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийн явцыг жил бүрийн 12 дугаар сард ажиглан Төрийн өмчийн хороо, авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үйлдвэрийн газрын нийт ажилтанд тайлагнана.

11.2. Үйлдвэрийн газар нь хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээ мэдээллийг цаг үеэ тэнцүүлж танилцуулж, хэрэгжилтэд Үйлдвэрийн газрын удирдлага, ажилтан хяналт үзүүлнэ.

11.3. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үйл ажиллагааны чанарын өөрчлөлт, өрсөлдсөн түвшингийн талаар удирдлага, ажилтан тодорхой санал, хүсэлт дэвшүүлнэ.

11.4. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, үйл ажиллагааны чанарын өөрчлөлт, өрсөлдсөн түвшинг үнэлж дүгнэх ерөнхий үзүүлэлтэд дараах үзүүлэлт хамаарна. Үүнд:

11.4.1. Ажилтны мэргэжил, боловсролоо дээшлүүлэхэд Үйлдвэрийн газрын зүгээс жилд төлөвлөн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн.

11.4.2. Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны төлөвлөлтийн хэрэгжилт, үр дүнд үзүүлэлт, түүнийг дээд газраас үнэлсэн үнэлгээ.

11.4.3. Ажилтан өөрсдийн мэргэжил, боловсролоо дээшлүүлэхэд хувийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн.

11.4.4. Ажилтны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, түүний үр дүнд удирдлагын өгсөн үнэлгээ.

11.4.5. Ажилтан ёс зүйн зөрчил гаргасан эсэх.